



720

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СӨЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2008 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 727

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагаан овогтой Тэгшжаргалыг Үндэсний статистикийн хорооны захиалгаар Япон Улсын Токио Олон улсын их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Оюунгэрэл овогтой Байгалмааг Үндэсний статистикийн хорооны захиалгаар АНУ-ын Масачусетсийн их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Пүрэвдорж овогтой Элбэгсайханыг Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар ОХУ-ын Онцгой байдлын яамны Гал эсэргүүцэх албаны академид галын инженерийн чиглэлээр, Нямсүрэн овогтой Даваанямыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Англи Улсын Лейкестер коллежийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Намхайнамбуу овогтой Анхтуяаг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Мэйний Өмнөдийн их сургуулийн магистрантурт сэтгэл зүйн чиглэлээр, Батбаатар овогтой Эрдэнэсүрэнг Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар АНУ-ын Калифорнийн Менежмент, шинжлэх ухааны их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Баярмөнх овогтой Хуланг Англи улсын Сvonci их сургуульд хуулийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

САЙД

Н.Болормаа

Н.БОЛОРМАА

09.10.11